



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026.03.25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.03.25 № 2/57
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тус байгууллага нь нийгмийн даатгалын сангийн нэхэмжлэлд суурилсан Sicos программыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050430
/2026 он/1. бичиг хэрэг/1001/2. а4-
албан тоот.docx

Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд өндөр насны тэтгэвэрт 13,736 иргэнд 122,825,978.4 мянга, жирэмсэн амаржсаны тэтгэмжид 766 иргэнд 5,243.639.9 мянга, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 369 иргэнд 746,000.0 мянга, хөдөлмөрийн чадвараа алсаны тэтгэмжид 295 иргэнд 135,437.5 мянга, ажилгүйдлийн тэтгэмжид 632 иргэнд 2,595,303.8 мянга, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг 30 иргэнд 381,650.0 мянга, нийт 131,928,009.6 төгрөгийг тус тус олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,440,229,525.46	13,584,757,545.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,657,562,447.45	8,749,626,574.82
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,657,562,447.45	8,749,626,574.82
31210	Төгрөг	8,657,562,447.45	8,749,626,574.82
31213	Арилжааны банк дахь харилцах	8,657,562,447.45	8,749,626,574.82
33	АВЛАГА	3,782,667,078.01	4,835,130,970.38
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,321,898,167.63	1,321,898,167.63
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	2,394,865,412.21	3,347,244,909.54
33500	Бусад авлага	65,903,498.17	165,987,893.21
33510	Байгууллагаас авах авлага	26,630,131.09	99,687,463.31
33520	Хувь хүмүүсээс авах авлага	39,273,367.08	66,300,429.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	12,440,229,525.46	13,584,757,545.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,487,698,342.47	3,871,908,490.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,487,698,342.47	3,871,908,490.42
41300	Өглөг	735,053,776.30	1,199,533,061.89
41360	Бусад өглөг	735,053,776.30	1,199,533,061.89
41361	Байгууллагад төлөх өглөг	61,934,291.16	119,152,086.39
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	653,440,163.65	1,060,701,654.01
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	19,679,321.49	19,679,321.49
41400	Урьдчилж орсон орлого	1,752,644,566.17	2,672,375,428.53
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,752,644,566.17	2,672,375,428.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,952,531,182.99	9,712,849,054.78
51	Засгийн газрын хувь оролцоо	9,952,531,182.99	9,712,849,054.78
51200	Хуримтлагдсан үр дүн	9,952,531,182.99	9,712,849,054.78
51210	Өмнөх үеийн үр дүн	10,390,271,457.74	9,909,646,653.04
51220	Тайлант үеийн үр дүн	- 437,740,274.75	- 196,797,598.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	12,440,229,525.46	13,584,757,545.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	158,899,726,699.58	185,878,045,545.18
11	ТАТВАРЫН ОРЛОГО	44,866,469,507.43	56,047,835,494.98
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	44,866,469,507.43	56,047,835,494.98
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэл	37,898,445,491.73	47,147,786,048.11
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	37,898,445,491.73	47,147,786,048.11
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	3,961,610,630.77	4,944,449,516.18

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,726,141,205.37	2,329,933,070.05
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,280,272,179.56	1,625,666,860.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,032,962.73	129,830,210,050.20
120	Нийтлэг татварын бус орлого	99,032,962.73	170,636,237.20
1201	Хүүгийн орлого	43,770,473.96	47,502,117.63
120002	Бусад хүүгийн орлого	43,770,473.96	47,502,117.63
120003	Торгуулийн орлого	417,000.00	4,878,900.00
120009	Бусад орлого	54,845,488.77	118,255,219.57
122	Тусламжийн орлого	-	129,659,573,813.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	129,659,573,813.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	20,930,236,000.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого /УТ-НДС/	-	20,930,236,000.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	108,729,337,813.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,934,224,229.42	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,388,948,179.42	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,388,948,179.42	-
1330	Төсвийн захирагчдаас	96,545,276,050.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,545,276,050.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	159,337,466,974.33	186,074,843,143.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,337,466,974.33	186,074,843,143.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,445,171.50	14,040,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,445,171.50	14,040,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,282,761.50	5,780,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,162,410.00	8,260,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,325,021,802.83	186,060,802,793.44
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	53,723,164,477.71
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	53,723,164,477.71
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	53,723,164,477.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,501,444,084.33	132,337,638,315.73
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	115,501,444,084.33	132,337,638,315.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,823,577,718.50	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,823,577,718.50	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	- 437,740,274.75	- 196,797,598.26
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	- 437,740,274.75	- 196,797,598.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	167,525,761,740.06	195,902,229,826.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	53,703,205,655.49	56,023,737,451.59
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	53,703,205,655.49	56,023,737,451.59
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	38,961,310,760.79	47,232,917,201.45
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	38,961,310,760.79	47,232,917,201.45
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	3,915,877,417.51	4,881,462,394.19
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,735,344,822.84	2,316,752,606.10
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,261,331,922.55	1,592,605,249.85
1121	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	7,829,340,731.80	-
112005	Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	7,829,340,731.80	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,784,134.57	139,878,492,374.61
120	Нийтлэг татварын бус орлого	117,784,134.57	10,218,918,561.61
1201	Хүүгийн орлого	43,834,268.62	47,506,870.09
120002	Бусад хүүгийн орлого	43,834,268.62	47,506,870.09
120009	Бусад орлого	73,949,865.95	10,171,411,691.52
122	Тусламжийн орлого	-	129,659,573,813.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	129,659,573,813.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	20,930,236,000.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого /УТ-НДС/	-	20,930,236,000.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	108,729,337,813.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	113,704,771,950.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,159,495,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,159,495,900.00	-
1330	Төсвийн захирагчдаас	96,545,276,050.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,545,276,050.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166,826,045,144.01	195,810,165,698.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,826,045,144.01	195,810,165,698.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,728,554.48	49,169,908.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,445,171.50	14,040,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,282,761.50	5,780,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,162,410.00	8,260,350.00

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,283,382.98	35,129,558.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,283,382.98	35,129,558.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,784,316,589.53	195,760,995,790.53
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	63,832,986,141.72
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	63,832,986,141.72
213104	НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	63,832,986,141.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,833,107,720.68	131,928,009,648.81
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	114,833,107,720.68	131,928,009,648.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,951,208,868.85	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,951,208,868.85	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	699,716,596.05	92,064,127.37
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	699,716,596.05	92,064,127.37
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,957,845,851.40	8,657,562,447.45
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,657,562,447.45	8,749,626,574.82

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,737,635,646.52	10,737,635,646.52	10,737,635,646.52
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 47,364,188.78	- 347,364,188.78	- 347,364,188.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,390,271,457.74	10,390,271,457.74	10,390,271,457.74
9	Тайлант үеийн үр дүн	- 437,740,274.75	-437,740,274.75	- 437,740,274.75
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,952,531,182.99	9,952,531,182.99	9,952,531,182.99
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,952,531,182.99	9,952,531,182.99	9,952,531,182.99
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 42,884,529.95	- 42,884,529.95	- 42,884,529.95
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,909,646,653.04	9,909,646,653.04	9,909,646,653.04
19	Тайлант үеийн үр дүн	- 196,797,598.26	- 196,797,598.26	- 196,797,598.26
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,712,849,054.78	9,712,849,054.78	9,712,849,054.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	77,135,531,700.00	77,102,301,243.72	33,230,456.28	100.0
11	Татварын орлого	56,205,295,700.00	56,172,065,243.72	33,230,456.28	99.9
112	Нийгмийн даатгалын орлого	56,205,295,700.00	56,172,065,243.72	33,230,456.28	99.9

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	49,060,517,900.00	47,362,166,437.76	1,698,351,462.24	96.5
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,038,561,300.00	4,887,396,713.32	- 848,835,413.32	121.0
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,690,853,500.00	2,318,195,951.41	- 627,342,451.41	137.1
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,415,363,000.00	1,604,306,141.23	- 188,943,141.23	113.3
12	Татварын бус орлого	20,930,236,000.00	20,930,236,000.00	-	100.0
122	Тусламжийн орлого	20,930,236,000.00	20,930,236,000.00	-	100.0
122001	Хандив тусламж /дотоод/	20,930,236,000.00	20,930,236,000.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,942,292,900.00	131,942,049,998.81	242,901.19	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,942,292,900.00	131,942,049,998.81	242,901.19	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,359,100.00	14,040,350.00	13,318,750.00	51.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,359,100.00	14,040,350.00	13,318,750.00	51.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,199,700.00	5,780,000.00	1,419,700.00	80.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,159,400.00	8,260,350.00	11,899,050.00	41.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,914,933,800.00	131,928,009,648.81	- 13,075,848.81	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,914,933,800.00	131,928,009,648.81	- 13,075,848.81	100.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	131,914,933,800.00	131,928,009,648.81	- 13,075,848.81	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-54,806,761,200.00	- 54,839,748,755.09	32,987,555.09	100.1
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,806,761,200.00	54,839,748,755.09	- 32,987,555.09	100.1
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	54,806,761,200.00	54,839,748,755.09	- 32,987,555.09	100.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,657,562,447.45		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,749,626,574.82		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----